



Эдийн засгийн өсөлт 16.7% (I улирал)

ДНБ 2012 оны эхний улиралд оны үнээр 2.3 их наяд төгрөг хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 30%, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 980 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 16.7% тус тус өссөн байна. ДНБ-ий бодит өсөлт ийнхүү 16.7% хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 дахин өндөр үзүүлэлт юм.




Төсвийн алдагдал 0.6 их наяд төгрөг хүрэх

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 22% өссөн бол зарлага түүнээс даруй 2.6 дахин хурдтай буюу 57% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 575 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүргэлээ. Орлого нэмэгдэхэд НӨАТ 29%, НДШ 50%, ААНОАТ 15%, ХАОАТ 54% тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин зарлага өсөхөд татаас ба шилжүүлэг 57%, хөрөнгийн зардал 103%, цалингийн зардал 38% өссөн нь нөлөөлөв.



Гадаад худалдааны алдагдал 1 тэрбум ам.доллараас давлаа

Нийт бараа эргэлт энэ оны II улирлын байдлаар 5.6 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18% нэмэгдсэн байна. Экспорт 14%, импорт 22% тус тус өссөнөөс гадаад худалдааны алдагдал нэг тэрбум ам.доллар хүрлээ. Экспортын өсөлтөд нүүрсний экспорт өмнөх оноос 48%, төмрийн хүдэр 30%, боловсруулаагүй газрын тос 41% өссөн нь нөлөөлжээ. Харин импортын өсөлтөд дизель түлшний импорт 57%, автобензин 51%, суудлын автомашины импорт 26% өссөн нь голлон нөлөөлөв.




Төгрөгийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байна

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш өмнөх сараас 0.8%, өнгөрсөн оны мөн үеэс 5.6% суларлаа. Гадаад валютын нийт албан нөөц өнгөрсөн сараас 2.5%, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14.4% нэмэгдэв. Он гарснаас хойш чангарах хандлагатай байсан төгрөгийн ханш сүүлийн саруудад харьцангуй тогтвортой, цаашлаад сулрах хандлагатай байна.



Жилийн инфляцын түвшин буурч байна


Улсын хэмжээгээр тооцсон жилийн инфляцын түвшин IV сард хамгийн өндөр буюу 16% хүрч байсан бол сүүлийн хоёр сард нийт 1.3% буурч 14.7% боллоо. Гэхдээ энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин өндөр зүүлэлт юм. Үнийн дундаж түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.7% нэмэгдэхэд хүнсний барааны үнэ 24.8%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 22.5% өссөн нь голлон нөлөөлжээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ


Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байна

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 22% нэмэгдэж, 7 их наяд төгрөгт хүрлээ. Харин өнгөрсөн сартай харьцуулахад 4.8% нэмэгджээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх сараас 14%, өнгөрсөн оноос 40% нэмэгдэж, нийт мөнгөний 12.6%-ийг эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс өсөхөд төгрөгийн болон гадаад валютын хадгаламж өссөн нь голлон нөлөөлжээ.




Валютын хадгаламж өсч байна

Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.2%, өнгөрсөн сартай харьцуулахад 3.4% нэмэгдэж, 4.4 их наяд төгрөгт хүрлээ. Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21% өссөн бол валютын хадгаламж 51% буюу бараг 2 дахин хурдтай өссөн байна. Валютын хадгаламжийн хувийн жин 29% хүрсэн бол төгрөгийнх өмнөх оноос 5 нэгжээр буурчээ.



Чанаргүй зээлийн хэмжээ буурч байна

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сартай харьцуулахад 3.2%, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38.8% нэмэгдэж, 6.3 их наяд төгрөг боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.5%, өнгөрсөн оноос 21% буурч, нийт зээлд эзлэх хувь 4.9% хүрэв.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > УИХ-ын ээлжит сонгууль болж өнгөрлөө. АН хамгийн олон суудал авсан байна.
- > Монголбанкны бодлогын хүү (өөрчлөлтгүй) 13.25% байна.
- > Хонгконгийн хөрөнгийн биржид энэ онд IPO хийхээр төлөвлөж буй компаниудын жагсаалтад Тавантолгойн нүүрсний орд багтаад байна.
- > ЗГ “Эрдэнэс МГЛ” компанийн давуу эрхийн хувьцааг иргэн бүртээ нэмж олгох шийдвэрийг баталлаа.
- > ЗГ “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөг баталлаа.
- > ЗГ Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай өрхийн 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 15 мянга, 18 ба түүнээс дээш насны хүнд 10 мянган төгрөгөөр тогтоолоо.

Хураангуй

Инфляцийн түвшин өндөр, төсвийн алдагдал нэмэгдсээр байгаа энэ нөхцөлд Монгол улс дан ганц мөнгөний төдийгүй төсвийн хатуу бодлого баримтлах нь зүйтэй гэдгийг олон улсын байгууллагууд сануулсан хэвээр байна. Төсвийн алдагдал энэ оны хоёрдугаар улирлын байдлаар 0.6 их наяд төгрөг, инфляцийн жилийн түвшин 14.7% хүрээд байгаа юм.

Монгол банкны бодлогын хүү 13.25% хэвээр байгаа ч инфляци өндөр, бодлогын хүү буюу ТБҮЦ-ны хүү өндөр байгаа нь арилжааны банкууд зээлээ хумьж, зээлийн хүү болон нөхцөлөө чангатгахад хүргэв. Мөнгөний урсгал нэмэгдэж байгаатай холбоотой зээлийн өндөр өсөлтөөс үүдсэн эрсдлээ бууруулах банкуудын сонирхол ч үүнд нөлөөлж байна.

Хоёр жилийн турш иргэн бүрт сар бүр олгож байсан 21 мянган төгрөгийн тэтгэмж энэ VI сараар дуусгавар боллоо. Хэдийгээр энэ нь инфляцийн дарамтыг бууруулах ч 21 мянган төгрөг гол орлого нь болоод байсан, инфляцийн өсөлт хамгийн их нөлөөлдөг эмзэг бүлгийн иргэдэд илүү хүнд нөхцөл үүсгэхээр байна.

Гэсэн ч бэлэн мөнгө тараах ажил үүгээр дуусаагүй, ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох 330 мянган төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хүсэлт гаргасан иргэдээс худалдан авч бэлэн мөнгө олгох, нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай иргэдэд олгох тэтгэмж зэрэг мөнгүүд хүлээж байна.

Валютын ханш бага багаар сулрах хандлага ажиглагдаж эхэлсэн нь экспортыг дэмжих ч импортын үнийг нэмэгдүүлж эргээд инфляцийн дарамтыг нэмэгдүүлж болзошгүй.